

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН ЦУВРАЛ МЭДЭЭ

www.eprc-chemonics.biz

2010 ОНЫ 1, 2 ДУГААР САР, №60

АНУ-ЫН ОУХА-ИЙН ХӨГЖЛИЙН ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР ЖДҮ-ИЙГ ДЭМЖИХ 25 САЯ АМ.ДОЛЛАРЫН ЗЭЭЛД БАТАЛГАА ГАРГАХ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ



2010 оны 1-р сарын 14-ний өдөр Хаан банкны дэд захирал Д.Батсайхан, АНУОУХА-ийн Суурин төлөөлөгч Чак Ховелл, Хас банкны гүйцэтгэх захирал М.Болд нар ХЗГ-ын Зээлийн баталгааны гэрээнд гарын үсэг зурлаа

Энэ 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр АНУ-ын ОУХА-ийн Суурин төлөөлөгч Чак Ховелл, Хас банкны гүйцэтгэх захирал М.Болд, Хаан банкны орлогч захирал Д.Батсайхан нар Монгол улсын жижиг, дунд үйлдвэрүүдэд (ЖДҮ) зориулж олгох 25 сая ам.долларын зээлд АНУ-ын ОУХА-ийн Хөгжлийн зээлийн хөтөлбөр (ХЗХ)-өөр

дамжуулан баталгаа гаргаж дэмжлэг үзүүлэх гэрээнд гарын

ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБАНААС ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛЖ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ГАРЫН АВЛАГА ХЭВЛЭН ГАРГАЛАА

Монгол Улсын Үндэсний Татварын алба ЭЗБШӨЧ төсөлтэй хамтран жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын гарын авлагыг энэ 2 дугаар сард эцэслэн боловсруулж, 3 дугаар сард хэвлэн гаргалаа. НӨАТ төлөгчөөр анх удаа бүртгүүлж буй татвар төлөгчдийн боловсролыг дээшлүүлэхэд зориулсан энэхүү гарын авлагад

мэдээллийг илүү ойлгомжтой хүргэхийн тулд татвар төлөгчөөр бүртгүүлэх, татварын тайлан гаргах хугацаа, татвар төлөлт, буцаан олголтыг тооцох зэргийг тодорхой жишээ, хүснэгтээр тайлбарласан болно.

Түүнчлэн уг гарын авлага нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй бизнес эрхлэгчдийг зохих мэдээллээр хангаж, татвар төлөгчөөр бүртгүүлэх хууль ёсны



ЭНЭ ДУГААРТ

- АНУ-ын ОУХА-ийн Хөгжлийн зээлийн хөтөлбөр ЖДҮ-ийг дэмжих 25 сая ам.долларын зээлд баталгаа гаргах гэрээнд гарын үсэг зурав
- Монголын Үндэсний татварын албанаас жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулж Нэмэгдсэн өртгийн албан татварын гарын авлага хэвлэн гаргалаа
- “Уул уурхайн олборлолтын салбарын компанийн нийгмийн хариуцлага” сэдэвт семинар болов
- Компанийн засаглалын хөгжлийн төв “Ерөнхийлөгчтэй хамт үдийн зоог барих” ажил хэрэгч уулзалт зохион байгууллаа
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар хамтран Замын-Үүдэд сэтгүүлчдэд зориулсан танилцах аялал зохион байгуулав

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ЦУВРАЛ НЭВТРҮҮЛЭГ

Халуун сэдэв нэвтрүүлэг

Транзит Монгол,
монгол, англи хэл дээр.

Компанийн засаглал,
монгол хэл дээр.

үсэг зурсан бөгөөд энэ нь АНУ-ын ОУХА-ийн ХЗХ-өөс тус улсад анх удаа зээлийн баталгаа гаргаж буй онцлог үйл явдал байлаа.

ХЗХ-ийн зээлийн энэхүү баталгааг тус улсын санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг эргэлтэд оруулах, хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтыг дэмжихэд ашиглана. Зээлийн эл баталгаагаар зээлдүүлэгчийн найдваргүй зээлийн эрсдэлийг 50 хүртэл хувиар барагдуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудад өөрийн хөрөнгөөр зээл олгох, шинэ тутам гарч ирж буй уламжлалт бус салбаруудын төслийг санхүүжүүлэхэд дотоодын санхүүгийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх аж. Өөрөөр хэлбэл ХЗХ-ийн зээлийн баталгаа нь зээлдүүлэгчдийн эрсдэлийг бууруулж, зээлжих чадвартай зээлдэгчдийн зээлийн эрсдэлийн дүн шинжилгээг сайжруулахад санхүүгийн байгууллагуудад туслах хамгийн зохистой арга хэрэгсэл болж байгаа юм.

Тус улсын санхүүгийн дийлэнх байгууллагуудаас ЖДҮ-т зээл олгоход хүндрэлтэй тулгардаг бөгөөд энэ нь тэдний менежментийн чадавхи сул, бизнесийн төлөвлөгөөгөө боловсруулах мэдлэг, боловсрол дутмаг, зээлийн барьцаа хөрөнгөгүй, зээлийн түүх байдаггүй зэрэг шалтгаантай холбоотой юм. ЖДҮ-т зээл олгоход тулгарч буй эдгээр бодит хүндрэл бэрхшээлтэй зэрэгцэн дэлхий нийтийн болон дотоодын санхүүгийн хямралын улмаас зээлийг хязгаарлаж, барьцаа хөрөнгөд ихээхэн

ач холбогдол өгч эхэлсэн нь байдлыг улам бүр хүндрүүлж байна. Тус улсын зарим банкууд ЖДҮ-т зээл олгохоо түр зогсоосон бөгөөд зарим нь өмнө нь авсан хоёр удаагийн зээлээ бүрэн төлж барагдуулсан, 100 хувийн барьцаа хөрөнгөтэй ЖДҮ-т зээл олгож байгаа аж. Монгол улсын ЖДҮ нь нийт аж ахуйн нэгжийн 90 орчим хувийг эзэлж, тэдгээрт 300,000 орчим хүн ажиллаж байна. ЖДҮ-ийн санхүүжилтийн эл хязгаарлагдмал байдал нь тэднийг бизнесээ өргөжүүлэн хөгжүүлж, ажлын байр шинээр бий болгох боломж бололцоонд шууд нөлөөлж байна.

ЖДҮ-т учирч буй санхүүжилтийн дээрх хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэхүүднээс ЭЗБШӨЧ төсөл зээлийн баталгааны хөтөлбөрт хамрагдсан үндэсний зээлдүүлэгч түнш байгууллагуудын хүсэл сонирхлыг тодорхойлох зах зээлийн анхны үнэлгээ, ЖДҮ-т олгох зээлийг дэмжих зорилго бүхий ХЗХ-ийн зээлийн багцын баталгаа (ЗББ)-г бий болгох техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж АНУ-ын ОУХА-т туслалцаа үзүүлсэн билээ. Түүнчлэн ЭЗБШӨЧ төслийн зүгээс санал болгож буй Монгол Улсын зээлдэгч байгууллагууд нь АНУ-ын Засгийн газартай эрсдэлээ хамтран хуваалцах итгэлтэй түншүүд мөн эсэхийг тодорхойлох эрсдэлийн үнэлгээ хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан юм. Хаан банк болон Хас банкны хувьд энэ хөтөлбөрт хамрагдахын чухлыг, мөн ЖДҮ-т бизнесийн төлөвлөгөөгөө амжилттай

хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлж, тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжтой болно гэж үзэж байгаагаа онцлон тэмдэглэсэн юм.

Судалгааны ажил, эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн АНУ-ын ОУХА, Хас банк, Хаан банк ЖДҮ-ийн зээлдэгчдэд зориулж ХЗХ-ийн 10 жилийн хугацаатай, 25 сая ам.долларын ЗББ гаргах боломж бололцоог бүрдүүлээд байна. Зээлийн энэхүү баталгааг хөдөө аж ахуй, барилга, орон сууцны салбарт ажиллаж буй болон логистик, уул уурхайн салбарын нийлүүлэлтийн үйл ажиллагаа явуулахаар шинээр байгуулагдсан ЖДҮ-т гаргах юм. ХЗХ-ийн баталгаа нь барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулж, илүү урт хугацааны зээл олгох явдлыг дэмжих замаар дээр дурьдсан зорилтот салбаруудыг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгоход тусална. Урт хугацааны зээл нь Монгол Улсын эдийн засагт нөлөөлж буй дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын сөрөг үр дагаврыг бууруулах, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахад шаардагдаж буй санхүүжилтийг ЖДҮ-т олгох боломж бололцоог бүрдүүлэх юм.

“УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА” СЭДЭВТ СЕМИНАР БОЛОВ

ЭЗЭБШӨЧ төсөл, Канад Улсын ЭСЯ, Канадын Агритим зөвлөх компани хамтран



2010 оны 1-р сарын 25-ны өдөр “Уул уурхайн олборлох салбар дахь компанийн нийгмийн хариуцлага” сэдэвт семинар болов

хөгжиж буй орнуудын уул уурхайн салбарт хурц асуудал болж байгаа “Хариуцлагатай уул уурхай: Компанийн нийгмийн хариуцлагын орчин үеийн чиг хандлага” сэдэвт хагас өдрийн семинарыг энэ оны 1 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Семинарын зорилго нь уул уурхайн үйл ажиллагааны компанийн нийгмийн хариуцлага (КНХ), түүний үүрэг ролийг тодорхойлох, орчин үеийн чиг хандлага, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлагыг танилцуулахад оршиж байв. Семинарыг Канад Улсын Элчин сайд, доктор Анна Байолик, ЭЗБШӨЧ төслийн Бодлого, сурталчилгааны зөвлөх Ребекка Дарлинг нар удирдан явууллаа. Семинарын үеэр ЭЗБШӨЧ төслийн Уул уурхайн ахлах зөвлөх Рена Гундуез, Канадын “Агритим” зөвлөх компанийн төслийн удирдагч Дэб Расмуссен, Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн

холбооны гүйцэтгэх захирал Ш.Шинэбаяр, “Оюу толгой” төслийн Олон нийттэй харилцах албаны ажилтан Б.Одгэрэл, “Бороо гоулд” ХХК-ийн Олон нийттэй харилцах албаны менежер Ч.Хатанбаатар, “Өмнөговийн Элс” компанийн гүйцэтгэх захирал Даве Бартел, “Төмөр Ерөө гол” ХХК-ийн ахлах геологич Б.Алтангэрэл нар илтгэл тавив.

Сүүлийн хорин жилд хийгдсэн хөрөнгө оруулагчдыг татах, эрх зүйн орчинг шинэчлэх, улмаар иргэдийг мэдээлжүүлэх үйл ажиллагаа нь уул уурхайн олборлох салбарт олон талт өөрчлөлт авчирч чадсан юм. Компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ын талаар тухайн гадаад болон үйл ажиллагаа явуулах хүлээн авагч улс оронд тавигддаг шаардлагуудыг дагаж мөрдөхийг компани, хөрөнгө оруулагчдаас шаардах боллоо. Ашигт малтмалын асар их нөөцтэй улс орнуудын хувьд уул уурхайн ил тод байдлыг

хангах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, хариуцлагатай хандах, ард иргэдийн буюу нийгмийн зөвшөөрөл авах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх агуулгаар КНХ нь хурц асуудал болж ирж байгаа бөгөөд оролцогч бүх талуудыг энэ асуудалд хамтран ажиллаж, уул уурхайн үйл ажиллагаанд өртөж буй тухайн орон нутаг, ард иргэд, улс орныг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр хөгжүүлэхийг шаардах болжээ.

Семинарын үеэр дараахь сэдвүүдийг хөндөв. Үүнд: Уул уурхайн олборлох салбарын нийгмийн хариуцлага; КНХ ба орон нутгийн үйлдвэр ахуйн газрын хөгжил; Уул уурхайн дотоод, гадаадын компанийн КНХ-ын санал санаачлага. Уг семинарт уул уурхайн компаниуд, уул уурхайн чиглэлийн төрийн бус байгууллагуудын (ТББ) төлөөлөл, төрийн албан хаагчид оролцлоо.



Семинарын илтгэлүүдэд КНХ-ын орчин үеийн чиг хандлага, арга зүйн асуудал хийгээд дан ганц капиталын нүсэр хөрөнгө оруулалтаас капиталын болон хүний нөөцийн хөгжлийг тэнцвэртэй хангасан хөрөнгө оруулалтад шилжихийн ач холбогдлын талаар онцлон тэмдэглэж байв. Семинарт илтгэл тавьсан хүмүүс болон оролцогчид аль аль нь уул уурхайн салбарын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нөлөөлж буй нөлөөллийн үр дагаврын хариуцлагыг компаниуд үүрэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байлаа. Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Ш. Шинэбаяр уул уурхайн үйл ажиллагаанд нэрвэгдэж буй орон нутгийн иргэдэд боловсрол олгох, тэднийг мэдээллээр хангахад туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ тэдэнд “загас барьж өгөхийг оронд загас барихад сургахад” анхаарах ёстойг онцолсон юм.

ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБАНААС ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛЖ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ГАРЫН АВЛАГА ХЭВЛЭН ГАРГАЛАА

Түрүүч нь нэгдүгээр нүүрт

үүрэг, ач холбогдол, үүний дотор татварын буцаан олголтын талаархи мэдээллээр хангаж, татвар төлөгчөөр бүртгүүлэх явдлыг хөхиүлэн дэмжихийг зорьж байна. Монгол Улсын Үндэсний татварын алба нь татвар төлөгчдөд зориулан

цуврал товхимол гаргаж байгаагийн сүүлчийнх нь эл гарын авлага бөгөөд энэ нь мэдээллийг татвар төлөгчдөд илүү хүртээмжтэй хүргэх, тэдэнтэй үр дүнтэй харилцах замаар харилцаагаа сайжруулах томоохон ажлын нэг хэсэг болж байгаа юм. Энэхүү гарын авлагыг Монгол Улсын ҮТА-ны www.mta.mn вэбсайтаас үзэж болно.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ “Ерөнхийлөгчтэй хамт үдийн зоог барих” АЖИЛ ХЭРЭГЧ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Компанийн засаглалын хөгжлийн төв (КЗХТ) энэ 2010 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын компанийн засаглалын асуудлаар ажил хэрэгч уулзалт зохион байгуулсан бөгөөд уг уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож, тус төвийн гишүүн болон ивээн тэтгэгч байгууллагуудад гишүүнчлэлийн батламж гардууллаа. Уулзалтад төр, хувийн хэвшил, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөлөл оролцов.

Уг уулзалтыг КЗХТ-ийн ТУЗ-ийн дарга Д.Батжаргал нээж, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож байгаа тухай танилцуулсан юм. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол улсын бизнесийн байгууллагуудын эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулахад компанийн засаглал онцгой ач холбогдолтой болох тухай, мөн дэлхий нийтийн

хэмжээнд компанийн засаглалын үүрэг роль улам бүр нэмэгдэж байгааг онцолж, тус улсын нийт бизнесийн байгууллагуудын хүрээнд компанийн сайн засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэхийг, мөн төрийн байгууллагуудын хүрээнд ч сайн засаглалыг дэмжиж ажиллахаа илэрхийллээ.

Уулзалтыг нээж, товч танилцуулга хийсний дараа уулзалтад оролцсон КЗХТ-ийн гишүүн байгууллагууд болох Хаан банк, Энержи Ресурс ХХК, Мобиком корпораци, Хас банк, Ньюком групп, Моннис групп, АПУ ХХК-ийн удирдлагууд тус улсын хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг сайжруулах, хөрөнгө татах боломж бололцоог нэмэгдүүлэхэд компанийн засаглалыг хэрхэн үр дүнтэй хөгжүүлэх талаар ярилцлага өрнүүлсэн юм.

Тэд КЗХТ-ийн үйл ажиллагаа, үүний дотор сургалт, компанийн засаглалын үнэлгээ хийх, олон нийттэй харилцах харилцаа, судалгаа, шинжилгээний ажлыг сайжруулах асуудлаар төвлөрч ярилцав. Уулзалтад оролцогчид компанийн засаглалын зарчмуудын олон улсын шилдэг туршлага, үйл ажиллагаатай нийцүүлэн КЗХТ-ийг хөгжүүлэхийн чухлыг онцолсон юм. Бизнесийн байгууллагуудын удирдлагуудын зүгээс өөрсдийн компани, улмаар Монгол улсын нийт бизнес эрхлэгчдийн хүрээнд компанийн засаглалыг сайжруулахад өөрсдийн хувь нэмрээ оруулах болно гэдгээ ч илэрхийлсэн. УИХ-ын гишүүн, профессор Р.Амаржаргал



2010 оны 1-р сарын 15-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвөөс “Ерөнхийлөгчтэй хамт үдийн зоог” уулзалт ярилцлага зохион байгуулав

КЗХТ-ийн үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой явуулахын тулд дотоодын сургагч багш нарыг бэлтгэх, тус төвийн менежментийн чадавхийг бэхжүүлэх зайлшгүй шаардлага байгааг хэллээ.

Энэхүү ажил хэрэгч уулзалтыг хааж Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Баярсайхан, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал нар үг хэлсэн бөгөөд тэд КЗХТ-ийг үүсгэн байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн АНУ-ын ОУХА-т талархаж байгаагаа илэрхийлж, тус төв нь бизнесийн хүрээнийхэн, их дээд сургууль, эрдэм шинжилгээ байгууллагууд, өргөн олон нийтийн зүгээс Монгол Улсад компанийн засаглалыг хөгжүүлэх явдлыг нэгэн дуу хоолойгоор дэмжихэд ихээхэн хувь нэмэр оруулах болно гэдгийг онцлон тэмдэглэсэн юм.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХАМТРАН ЗАМЫН-ҮҮДЭД СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ТАНИЛЦАХ АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Энэ 2 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд сэтгүүлчдэд зориулж эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт шалгалтын хэрэгжилтийн өнөөгийн байдал, хилийн нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх эхний шатны ажилтай

газар дээр нь танилцаж, мэдээлэл олж авах танилцах аяллыг Замын-Үүдэд зохион байгуулсан бөгөөд уг аялалд 8 телевиз, 12 өдрийн сонин, МОНЦАМЭ агентлаг, Монголын Радиогийн 30 сэтгүүлчид оролцлоо.

Танилцах аяллыг Монголын Хэвлэлийн хүрээлэн (МХХ), ЭЗБШӨЧ төслийн дэмжлэгтэйгээр Гаалийн ерөнхий газар (ГЕГ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) зохион байгуулав. Замын-Үүдэд аялах танилцах эл аяллын өмнө буюу 2 дугаар сарын 24-ний өдөр Замын-Үүдэд хийх аялал, орон нутгийн онцлогийн талаар мэдээлэл өгч, ярилцлага хийх хүрээг тогтооход туслах зорилгоор эдгээр сэтгүүлчидтэй уулзалт зохион байгуулсан юм.

Аяллын өмнөх энэхүү уулзалтад ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын албаны дарга Б.Лхагвадорж оролцож, тус газарт хэрэгжиж буй Гаалийн эрсдэлийн удирдлагын (ГЭУ) талаар танилцуулсан. Түүнчлэн ЭЗБШӨЧ төслийн техникийн туслалцааны хүрээнд ГЭУ-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шинэ программ



2010 оны 2-р сарын 27-28-ны өдрүүдэд сэтгүүлчид Замын-Үүдийн гааль, мэргэжлийн хяналтын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцлаа



хангамжийг боловсруулж ажиллуулсан нь ГЭУ-ын хөтөлбөрийг амжилтад онцгой нөлөөлсөн тухай тэрээр дурьдсан юм. Түүнчлэн ГЕГ бизнесийн хүрээнийхэн, ялангуяа экспорт, импортын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд, гаалийн брокеруудтай тогтоосон түншлэлийн харилцаагаа цаашид улам бүр бэхжүүлэх нь ГЭУ-ыг амжилттай хэрэгжүүлэх үндэс болох тухай дэлгэрэнгүй тайлбарлав. ГЕГ нь 175 орныг эгнээндээ нэгтгэсэн Дэлхийн Гаалийн байгууллагын гишүүн бөгөөд эдгээрээс 120 гаруй улс ГЭУ-ыг хэдийнээ

нэвтрүүлж, хэрэгжүүлээд байгаа тухай, мөн Монгол улс өөрийн стандартаа өндөржүүлж, олон улсын шилдэг, туршлага, арга ажиллагаатай нийцүүлэхийн чухлыг онцолсон.

Уулзалтын үеэр ГЕГ-ын дэд дарга Д.Оюунчимэг ГЭУ-ын талаар илтгэл тавьж, МХЕГ зэрэг хилийн хяналтыг хэрэгжүүлдэг бүх байгууллагуудын хамтын ажиллагааны ач холбогдол, хилийн хяналт шалгалтад зарцуулж буй цаг хугацааг богиносгохын тулд тэд нягт хамтран ажиллах шаардлага байгааг онцлон тэмдэглэв. МХЕГ-ын Эрсдэлийн үнэлгээ, удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Э.Мөнхөө хяналт шалгалтын тоог цөөлж, цаг хугацаа хэмнэх зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн эрсдэлийн удирдлага, хяналт шалгалтын ажиллагааг илүү боловсронгуй болгох чиглэлд хийж буй ажлынхаа талаар танилцуулав. ЭЗБШӨЧ төслийн эдийн засаг, худалдааны бодлогын шинжээч С.Отгонбаяр төр, хувийн хэвшлийн түншлэлийн механизмыг ашиглан шилжүүлэн ачих байгууламжийг сайжруулах зорилго бүхий Замын-Үүдийн логистик паркийн санал болгож буй төслийн талаар мэдээлэл өглөө. Эдгээр илтгэлийн дараа Замын-Үүдэд зохион байгуулах танилцах аялалд бэлдэж тодорхой сэдвүүдээр ярилцах, үзэл бодлоо илэрхийлэх, ярилцлага авах асуултуудыг боловсруулахын тулд Хэвлэлийн хүрээлэнгээс сэтгүүлчдийг ярилцлагын сэдвүүдээр бүлгүүдэд хувааж, бүлгээр ажиллуулан уулзалтыг өндөрлөсөн юм.

Замын-Үүдэд танилцах аялал хийсэн сэтгүүлчид хилийн хяналтын бүх цэг, байгууламжууд, тухайлбал шилжүүлэн ачих байгууламж, импортын барааг шинжлэх лаборатори, хяналтын талбай, рентген байгууламж болон хяналт шалгалт, бүрдүүлэлт, шилжүүлэн ачих байгууламжийн ажиллагаатай

СОНИНД ГАРСАН НИЙТЛЭЛҮҮД...

“Гаалийн байгууллага худалдааг хөнгөвчлөхөд түлхүү анхаарч байна”

*“Өглөөний сонин” №041,
2010.02.03.*

“Замын-Үүдийн чөлөөт бүс байгуулахад 10-15 тэрбум ам.доллар хэрэгтэй”

*“Зууны мэдээ” №049,
2010.03.02.*

“Ч.Баатар: Замын-Үүдийн чөлөөт бүсийг барих сонирхлоо АНУ илэрхийлсэн”

*“Монголын мэдээ” №045,
2010.03.04.*

“Гаалийнхан худалдааг хөнгөвчлөн ажиллахад бэлэн байна”

*“Монголын мэдээ” №043,
2010.03.02.*

“Замын-Үүдийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд энэ жил тэрбум төгрөг зарцуулна”

*“Ардчилал” №065,
2010.02.23.*

газар дээр нь танилцаж зохих мэдээлэл авсан юм. Танилцах аялалд оролцсон ЭЗБШӨЧ төслийн ажилтан С.Отгонбаяр хилийн хяналтын үйл ажиллагаа, гадаад худалдааг хөнгөвчлөхөд хяналт шалгалтын өнөөгийн давхардсан ажиллагаа, дэд бүтцийн боломж бололцоо хэрхэн сөргөөр нөлөөлж буй талаар тайлбарлав. Замын-Үүд дэх Гааль, Мэргэжлийн хяналтын албаны ажилтнуудын зүгээс хяналт шалгалт, бүрдүүлэлтийн ажиллагааг илүү хялбаршуулахын тулд хяналтын одоогийн талбайг өргөжүүлэхээр санал болгож буй төслийн талаар танилцууллаа.

Замын-Үүд дэх хилийн хяналтын байгууламжуудыг харьцуулах боломж олгохын тулд сэтгүүлчдийг хөрш зэргэлдээ орших БНХАУ-ын Эрээн боомтод аялуулж, хөрөнгө оруулалтын үр дүнд байгуулагдсан шилжүүлэн ачих байгууламж бүхий орчин үеийн логистик паркийн үйл ажиллагаатай танилцуулсан юм. Сэтгүүлчид Эрээн хотын логистик төв, хорио цээрийн албаны талбай, тэнд явагдаж буй Хятадын гаалийн албаны ажилтнуудын зохион байгуулалттай, шуурхай үйл ажиллагааг Замын-Үүдийн өнөөгийн ажиллагаатай харьцуулж, эдгээр байгууллагуудын хооронд маш их ялгаа байгааг олж харсан юм.

Замын-Үүд нь БНХАУ-тай хиллэдэг өмнөд хилийн “хуурай газрын гол боомт” бөгөөд энэ боомтоор импортын урсгалын 90 орчим хувь, экспортын урсгалын 75 хувь гарч/орж байна. Энэ боомт нь Монгол Улсыг дэлхийн улс орнуудтай холбох гол “гарц” болж байгаа боловч түүний ажиллагаа нь ажил, үйлчилгээний зардлыг ихээхэн нэмэгдүүлэн, худалдааг хүндрүүлж тус улсын өрсөлдөх чадварт нөлөөлж буй “үл үзэгдэх” саад тотгор болж байна. Замын-Үүдийн дэд бүтцийн сул байдал, улмаар хилийн хяналтын менежментийн нэгдмэл байдал, зохион байгуулалт хангалтгүй байгаа нь Дэлхийн Банкны 2010 оны “Бизнес эрхлэх” судалгааны “Хилийн худалдаа”-ны индексээр 155 дугаар байрт орсны гол шалтгаан болж байна.

Замын-Үүдийн Гааль, Мэргэжлийн хяналтын албаны ажилтнуудтай хийсэн ярилцлага нь Замын-Үүдтэй холбоотой асуудлуудыг ойлгоход хангалттай мэдээлэл өгч, “хилийн хяналт, бүрдүүлэлтийн ажиллагаа, үүний дотор гааль, мэргэжлийн хяналт, хилийн хяналтын ажиллагаатай газар дээр нь танилцсан нь эдгээр асуудлуудын талаархи тэдний мэдлэгийг баяжуулж, ойлголтыг сайжруулсан”, улмаар “Замын-Үүд нь тус улсын гадаад худалдаанд онцгой нөлөөтэй болох тухай суралцлаа” гэж сэтгүүлчид санал сэтгэгдлээ хэлсэн юм. Энэ арга хэмжээний дараа танилцах аялалд оролцсон 8 телевиз, 12 өдрийн сонин, Монголын Үндэсний Радио, МОНЦАМЭ агентлагийн сэтгүүлчид Замын-Үүд дэх Гааль, Мэргэжлийн хяналтын албадын хил дээрх хяналт шалгалт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар нийтлэл бэлдэж, эдгээр байгууллагын эн тэргүүний зорилго, зорилт, санал санаачлагын талаар олон нийтэд мэдээлэл хүргэж туслалцаа үзүүлсэн билээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан эдгээр мэдээлжсэн, тодорхой сэдвийг хөндсөн мэдээлэл нь Монгол Улсын хуурай замын гол гарц болох Замын-Үүдийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийг төлөвлөгөөг олон нийтэд таниулан ойлгуулахад ихээхэн ач холбогдолтой болсон юм. Танилцах аяллын талаар сонин, хэвлэлд гарсан нийтлэлүүдийн дэлгэрэнгүйг “*Сонинд гарсан нийтлэл*” хэсгээс үзнэ үү.

Энэхүү цуврал мэдээ нь ЭЗБШӨЧ төслөөс сар тутам гаргадаг цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл: fbertoli@eprc-chemonics.biz or факс: (976-11) 32 78 25.